

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2019-04-02**

Тендер шалгаруулалтын нэр: **“Спорт заалны барилга /Дундговь аймаг, Говь-угтаал сум/” ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **БСШУСЯ/201902356**

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Спорт заалны барилга /Дундговь аймаг, Говь-угтаал сум/” ажлыг** гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2017, 2018 оны борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн **80 хувиас** багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2017, 2018**

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл / гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээн авсан тухай акт / ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил 2017, 2018**

Уг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай:

Хуучин: **Барилга угсралтын**

- **2.1.1.** Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
- **2.1.1.*** Барилгын засал чимэглэл, интерьерийн ажил
- **2.1.2.** Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1- 5 давхар хүртэл)
- **2.1.3.** Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-9 давхар хүртэл)Ган бүтээцэн барилгын ажил (фермийн алгасал нь 18 м, баганын өндөр нь 6 м хүртэл)
- **2.2.2.** Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
- **2.2.4.** Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Шинэ:

- БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил
- БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
- БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ,

тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,
- БА-4.4. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

/Туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./
Тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүйцүүлж үзнэ.

Цахим тендерт оролцогч нь Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.

10.000.000 /арван сая/ төгрөг

Хүчинтэй байх хугацаа: **2019 оны 07 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2019 оны 05-р сарын 03-** ны өдрийн **10** цаг **30** минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05-р сарын 03** -ний өдрийн, **11** цаг **00** минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг
доорх хаягаар авч болно.

Дундговь аймаг, Орон нутгийн өмчийн газар
Утас: 70593399